

# МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, УУЛ УУРХАЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2012 оны 10 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар А-171/46

Улаанбаатар  
хот

## Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Өрсөлдөөний тухай хуулийн 13.3 дугаар заалт, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

Нэг. “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дэд хөтөлбөрийн хүрээнд оролцогч банктай гэрээ байгуулан хэрэгжүүлж, хяналт тавихыг Монголбанкны Валют, эдийн засгийн газар /Д.Дэлгэрсайхан/-т, гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хэрэгжүүлж, хяналт тавихыг Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Р.Жигжид/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг улирал тутам Монголбанкны Захирлуудын зөвлөл, Уул уурхайн яамны Сайдын зөвлөлд тус тус танилцуулахыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба /Д.Ган-Очир/, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /Ч.Отгочулуу/-т тус тус даалгасугай.

Н. ЗОЛЖАРГАЛ  
МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Д. ГАНХУЯГ  
УУЛ УУРХАЙН САЙД

## ШАТАХУУНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДААНЫ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР (SIFS)

### Нэг. Зорилго

Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр /цаашид “SIFS хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь жижиглэнгийн газрын тосны бүтээгдэхүүний импортыг Монголбанкнаас тогтоосон хүүгээр санхүүжүүлэх, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах замаар шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгахад оршино.

### Хоёр. SIFS хөтөлбөрийн нөхцөл

SIFS хөтөлбөрийн ерөнхий нөхцөлийг дараах байдлаар тодорхойлов:

- **Үндсэн зорилго:** Жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгах<sup>1</sup>
  - **Хэрэгжүүлэх механизм:** Санхүүжилтийн өртгийг багасгах, хил дээрх өртгийн валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах,
  - **Хэрэгсэл:** Монголбанкнаас тогтоосон хүүгээр зээлийн шугам нээх, санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглах,
  - **Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил хүртэл
  - **Санхүүжилтийн нийт дүн:** 167 тэрбум төгрөг – Шатахууны жижиглэнгийн худалдааны 2 сарын дундаж хэрэгцээнээс ихгүй
- (Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар өөрчлөлт оруулсан).*
- **Эцсийн үр дүн:** жижиглэнгийн худалдааны шатахууны үнэ тогтвортой байх, газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх цаг хугацааны боломжийг олгох.

### Гурав. Хэрэгжүүлэх байгууллага

SIFS хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монголбанк, Уул уурхайн яам, SIFS хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээг Уул уурхайн яамтай байгуулсан, тусгай зөвшөөрөл эзэмшигч, жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд болон хэрэгжүүлэгч компанийн сонгосон дотоодын банкууд оролцоно.

### Дөрөв. SIFS хөтөлбөрийн зохион байгуулалт

Монголбанк нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. SIFS хөтөлбөрийн ерөнхий нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах, хөтөлбөрийг дуусгавар болгох, үргэлжлүүлэх асуудлыг Уул уурхайн яамтай хамтран шийдвэрлэнэ.
2. Уул уурхайн яамнаас гаргасан жижиглэнгийн худалдааны тооцоо, мэдэгдэлд үндэслэн хэрэгжүүлэгч компанид дараах нөхцөлтэй санхүүжилтийг оролцогч банкаар дамжуулан олгоно:

Зээлийн зориулалт:

Шатахууны жижиглэнгийн худалдааны импортын төлбөр тооцоо

<sup>1</sup> Гадаад нөхцөл байдалд огцом өөрчлөлт ороогүй нөхцөлд

- |                         |   |
|-------------------------|---|
| - Зээлийн төрөл:        | Зээлийн шугам   |
| - Зээл авах хэлбэр:     | Бэлэн бус   |
| - Зээлийн дээд хязгаар: | Тооцоонд тусгагдсан дүн   |
| - Зээлийн хүү:          | Монголбанкнаас тогтоосон хүү <sup>2</sup> +оролцогч банкны хүүний маржины дээд хязгаар <sup>3</sup> |
| - Зээлийн хугацаа:      | 1 жил (Зээлийн үйлчлэх хугацаа 1 жил ба нийт хугацаа 3 жилээс хэтрэхгүй байна)                      |
| - Үйлчилгээний шимтгэл: | Оролцогч банктай тохиролцоно.   |

3. Шатахууны жижиглэнгийн худалдааны импортын валютын ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийг дараах нөхцөлөөр оролцогч банкаар дамжуулан хэрэгжүүлэгч компанид санал болгоно:

- |                     |                                      |
|---------------------|--------------------------------------|
| - Зориулалт:        | Ханшийн эрсдэлийг бууруулах          |
| - Хэрэгслийн төрөл: | Санхүүгийн үүсмэл хэрэгсэл           |
| - Төгрөгийн хүү:    | Монголбанкнаас тогтоосон хүү         |
| - Ам.долларын хүү:  | Libor хүү                            |
| - Хугацаа:          | <del>2 сар хүүртэл</del> 2, 4, 6 сар |

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн сайдын 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А-187/183 дугаар хамтарсан тушаалаар өөрчлөлт оруулсан\).](#)

- |                         |  |
|-------------------------|--|
| - Үйлчилгээний шимтгэл: | Оролцогч банктай тохиролцоно   |
| - Бусад нөхцөл:         | Хэрэгжүүлэгч компани нь санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглаагүй нь үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл, шалтгаан болохгүй. |

4. Хэрэгжүүлэгч компанийн сонгосон оролцогч банктай гэрээ байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавина.
5. Банктай байгуулсан санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн нэгдсэн мэдээг сар тутам гаргаж, нийтэд мэдээлнэ.
6. SIFS хөтөлбөрийн ерөнхий нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хөтөлбөрийг дуусгавар болгох, үргэлжлүүлэх асуудалтай холбоотойгоор Уул уурхайн яамнаас мэдээ, мэдээлэл, тайлбарыг гаргуулан авах, хүргүүлсэн саналд ажлын 10 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд Монголбанкны саналыг дэмжсэнд тооцож, хэрэгжилтийг хангуулна.
7. Монголбанкнаас зөвхөн энэ SIFS хөтөлбөрт зориулж гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан сар тутам хүүг тооцож, зарлана.
8. Гадаад зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан энэхүү SIFS хөтөлбөрт тусгасан санхүүжилт, санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг гаргана.
9. Оролцогч банкны жагсаалтыг гаргаж, түүнд нэмэлт өөрчлөлт оруулна.
10. Шатахууны үнийг тогтворжуулахтай холбоотой бодлогын асуудлын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Уул уурхайн яамнаас авна.
11. SIFS хөтөлбөрийг хэрэгжүүлэх компанийг Уул уурхайн яамтай хамтран сонгон шалгаруулж, компанитай байгуулах гэрээний төсөлд саналаа өгөх, байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
12. SIFS хөтөлбөрийн санхүүжилт олгох тооцоог хянан үзэж, саналаа Уул уурхайн яаманд өгөх, харилцан тохиролцож дүнд нь өөрчлөлт оруулна.

<sup>2</sup> Монголбанкнаас зөвхөн энэ хөтөлбөрт зориулж үнийн тогтвортой байдалтай уялдуулан сар тутам тооцож, зарлах зээлийн хүүг хэлнэ

<sup>3</sup> Монголбанкнаас зөвхөн энэ хөтөлбөрт зориулж үнийн тогтвортой байдалтай уялдуулан сар тутам тооцож, зарлах оролцогч банкны нэмэх хүүний дээд хязгаарыг хэлнэ

13. Оролцогч банктай байгуулсан гэрээгээ биелүүлэхгүй байгаа хэрэгжүүлэгч компанийг SIFS хөтөлбөрөөс хасуулах, холбогдох хариуцлагыг ногдуулах саналыг Уул уурхайн яаманд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
14. Уул уурхайн яамны хүсэлтийн дагуу оролцогч банкны талаарх асуудлыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд хэсэгчилсэн шалгалтыг зохион байгуулна.
15. Уул уурхайн яамтай хамтран дэд хөтөлбөрийн арга хэрэгслийг зах зээлийн зарчимд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлнэ.

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан\).](#)

16. Уул уурхайн яамтай хамтран хэрэгжүүлэгч компаниудад хэсэгчилсэн шалгалтыг зохион байгуулна.

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан\).](#)

17. Шатахууны өртгийн өөрчлөлттэй уялдуулан санхүүгийн үүсмэл хэрэгслийн ханшийг өөрчлөн тооцно.

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан\).](#)

Уул уурхайн яам нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. SIFS хөтөлбөрийг хэрэгжүүлэх компанийг Монголбанктай хамтран сонгон шалгаруулж, хэрэгжүүлэгч компанитай байгуулах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:
  - Жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгах,
  - Санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу ашиглах,
  - Оролцогч банктай санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцэл хийж, ханшийн эрсдэлийг бууруулах,
  - Хэрэгжүүлэгч компани нь санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглаагүй нь шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ өсгөх үндэслэл, шалтгаан болохгүй байх,
  - Сонгосон банкныхаа зээлийн ерөнхий шаардлагыг хангаж байх,
  - Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах,
  - Шатахууны хилийн үнийн өсөлт, ханшийн өөрчлөлтийг борлуулалтын үнэд 6 сарын дотор шингээх

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А-187/183 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан\).](#)

2. Санхүүжилтийн дүнг жижиглэнгийн худалдааны мэдээн дээр үндэслэн хэрэгжүүлэгч компани тус бүрээр шинэчлэн тооцож байна. Санхүүжилтийн дүнг жижиглэнгийн худалдааны мэдээ, ШТС-ын тоо зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн хэрэгжүүлэгч компани тус бүрээр шинэчлэн тооцож байна

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар өөрчлөлт оруулсан\).](#)

3. Хэрэгжүүлэгч компанитай байгуулсан гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.
4. SIFS хөтөлбөрийн ерөнхий нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хөтөлбөрийг дуусгавар болгох, үргэлжлүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх компанийг сонгон шалгаруулах асуудлаар Монголбанктай хамтран ажиллана.

5. SIFS хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны хариуцан гүйцэтгэж буй үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хэрэгжүүлэгч компанийн тавьж буй саналыг Монголбанкинд уламжилж, шийдвэрлүүлнэ.
6. SIFS хөтөлбөрт оролцогч банкуудтай Монголбанкны байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавихад төлөөллөө оролцуулж болно.
7. Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, жижиглэнгээр худалдах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
8. SIFS хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг Монголбанкт хамтран сар тутам олон нийтэд мэдээлж байна.
9. Бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал тутам олон нийтэд мэдээлнэ.
10. SIFS хөтөлбөрийг хэрэгжүүлэх компанийг сонгон шалгаруулах, компанитай гэрээ байгуулахдаа Монголбанкнаас санал авна.
11. Хэрэгжүүлэгч компанитай байгуулсан гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих зорилгоор дараах ажлыг гүйцэтгэнэ:
  - Жижиглэнгийн худалдааны мэдээг гаргах журам, зааврыг батлан мөрдүүлэх,
  - Жижиглэнгийн худалдааны тайланг сар тутам авч, нэгтгэлийг гүйцэтгэх,
  - Санхүүжилтийн тооцоог өөрчлөх саналыг боловсруулах, шийдвэрлүүлэх,
  - Хэрэгжүүлэгч компаниас ирүүлсэн сарын тайлан мэдээнд шалгалт зохион байгуулах.
12. Шатахууны импортын зах зээлийн дараах мэдээллийг ил тод, нээлттэй болгоно:
  - Гадаад худалдааны мэдээ /импортлогч, дүн, хилийн үнэ/
  - Импортын шатахуунд ногдуулж буй татварын хэмжээ
  - Жижиглэнгийн худалдааны үнэ
  - Тусгай зөвшөөрөл бүхий компаниудын жагсаалт
  - Газрын тосны бүтээгдэхүүний худалдааны мэдээ /жижиглэн болон бөөний/
  - Жижиглэнгийн үнийн өөрчлөлтийн шалтгаан, үнэ бүрдэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А-187/183 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан\).](#)
13. SIFS хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлөх бодлогын шийдвэр гаргахдаа Монголбанкт зөвшилцөж байна.
14. Уул уурхайн яам нь SIFS хөтөлбөрийн хэрэгжих хугацаанд хавсралтад заасан бодлогын зорилтод хүрээгүй тохиолдолд гарах үр дагаврыг дангаар хариуцна.
15. Шатахууны хилийн үнийн өсөлт, ханшийн өөрчлөлтийг борлуулалтын үнэд 6 сарын дотор шингээх.

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А-187/183 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан\).](#)
16. Шатахууны хилийн үнийн өсөлт, ханшийн өөрчлөлтийг жижиглэнгийн үнэд зөвхөн Монголбанкны зөвшөөрлийн дагуу шингээнэ.

[\(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А-187/183 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан\).](#)
17. Шатахууны өртгийн өөрчлөлтийг жижиглэнгийн худалдааны үнэд шингээх саналыг сар бүрийн 10-ны өдөрт багтаан Монголбанкинд хүргүүлэх, хүргүүлсэн саналд ажлын 7 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд Уул уурхайн яамны саналыг дэмжсэнд тооцож, хэрэгжилтийг хангуулна.

(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан).

18. Шатахууны импортын татварыг хилийн үнийн бууралттай уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан).

19. Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ бүрдэлтийг сар бүр тооцож, үнийн өөрчлөлтийг тухайн сардаа багтаан олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.

(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан).

20. Монголбанктай хамтран дэд хөтөлбөрийн арга хэрэгслийг зах зээлийн зарчимд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлнэ.

(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар нэмж оруулсан).

### **Тав. SIFS хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ**

SIFS хөтөлбөрийн хүрээнд Уул уурхайн яам болон шатахууны импортлогч компаниуд нь дараах бодлогын зорилтыг хэрэгжүүлнэ.

<b>Зорилт</b>	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Хугацаа</b>
Шатахууны биет нөөцийг хадгалах савыг барих ажлыг эхлүүлнэ.	Шатахууны биет нөөц бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох, санхүүгийн эх үүсвэрийг нийдвэрлүүлэх	2012 оны 4-р улирал
Шатахууны биет нөөцийг нэмэгдүүлнэ.	Хувийн хэвшлийн компаниудын шатахууны нөөцийг бүрдүүлэх	2012 оны 4-р улирал
Шатахууны нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	ОХУ-аас бусад улсаас, тухайлбал БНСУ-аас авч буй шатахууны импортод учирч буй саад бэрхшээлийг судалж, холбогдох газраар нийдвэрлүүлэх	2012 оны 4-р улирал
Татварын зохицуулалтыг еэргээнэ.	Шатахууны импортын татварыг хилийн үнийн бууралттай уялдуулан еэргээж, татварын зохицуулалтын өрөн зайг нэмэгдүүлэх	2012 оны 4-р улирал

<b>Зорилт</b>	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Хугацаа</b>
Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ бүрдэлтийг ил тод болгоно.	Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэд нөлөөлж буй хүчин зүйлс (хилийн үнэ, татвар, валютын ханш, бусад)-ийг УУЯ, ГТГ-ын цахим хуудсаар дамжуулан сар бүр олон нийтэд зарлах	2014 оны 1-р сар
Шатахууны нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлнэ.	ОХУ-аас бусад улсаас, тухайлбал БНСУ-аас авч буй шатахууны импортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	2014 он

---

Татварын зохицуулалтыг  
нэмэгдүүлнэ.

Шатахууны импортын татварыг хилийн үнийн  
бууралттай уялдуулан тогтоож, татварын  
зохицуулалтын орон зайг нэмэгдүүлэх

2014 он

---

(Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А-30/37 дугаар хамтарсан тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан).

### **Зургаа. SIFS хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн**

1. Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ тогтворжино.

- Санхүүжилтийн зардал буурна.
- Ханшийн эрсдлийг бууруулна.

2. Бусад үр дүн

- Шатахууны импортын татварыг хилийн үнэтэй уялдуулан тогтоодог болно.
- Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг хадгалах савыг барьсан байна.
- Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нэмэгдсэн байна.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэр төрөлжинө.

--- оОо ---